

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
19. дугаар тогтоолын Гуравдугаар хавсралт
УХА 0163

**БИРЖИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАРИМ ОРОЛЦОГЧИЙГ ИТГЭМЖЛЭХ,
ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү журмаар "Монголын хөрөнгийн бирж" ХК /цаашид "Бирж" гэх/-иар арилжаалах бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарыг баталгаажуулах, бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх болон агуулах, терминал, тээвэр логистик, шинжилгээний лабораторийг зах зээлийн оролцогчоор бүртгэж итгэмжлэх, түүнтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү журам нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/ болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.3 Биржээр арилжаалагдах болон арилжаалагдсан уул уурхайн бүтээгдэхүүнийг агуулах, терминалд байршуулж, тээвэр логистикийн компаниар тээвэрлүүлж, шинжилгээний лабораторид шинжлүүлэхэд зөвхөн биржийн итгэмжлэгдсэн этгээдээр үйлчлүүлнэ.
- 1.4 Энэхүү журамд заасан нэр томьёог Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан утгаар ойлгож хэрэглэнэ.
- 1.5 Энэхүү журамд орох нэмэлт өөрчлөлтийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТҮЗ" гэх/ баталж, Хороо батламжилна.

Хоёр. Биржийн зах зээлийн оролцогч этгээдээр бүртгэж итгэмжлэх

- 2.1. Бирж нь энэхүү журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдийг дараах төрлийн үйл ажиллагаа явуулах итгэмжлэгдсэн этгээдээр бүртгэж, итгэмжилнэ. Үүнд:
 - 2.1.1. Агуулах;
 - 2.1.2. Терминал;
 - 2.1.3. Тээвэр логистик;
 - 2.1.4. Шинжилгээний лаборатори;
- 2.2. Биржийн итгэмжлэл нь тухайн этгээдийг зөвхөн Биржийн зах зээлийн оролцогч болохыг илэрхийлнэ.
- 2.3. Энэ журмын 2.1-д заасан үйл ажиллагаа явуулагч этгээдийг давхардуулан итгэмжилж болно.
- 2.4. Итгэмжлэл хүссэн хуулийн этгээд нь итгэмжлэл хүссэн албан хүсэлтээ дараах баримт бичгийн хамт цахим хэлбэрээр Биржид ирүүлнэ. Үүнд:
 - 2.4.1. Итгэмжлэл хүссэн өргөдөл, (энэхүү журмын нэгдүгээр хавсралт);
 - 2.4.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - 2.4.3. Хүсэлт гаргасан үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлтэй тохиолдолд тусгай зөвшөөрөл;

- 2.4.4. Аж ахуйн нэгжийн дүрэм;
- 2.4.5. Энэхүү журмын 3 дугаар бүлгийн хүрээнд тодорхойлсон нөхцөл, шаардлагуудыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 2.4.6. Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад.
- 2.5. Бирж нь шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга, баримт бичиг шаардаж болно.
- 2.6. Хүсэлт гаргасан этгээдийг итгэмжлэх эсэх талаарх шийдвэрийг баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Биржийн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 2.7. Энэхүү журамд өөрөөр заагаагүй бол итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэл нь 3 хүртэл жилийн хугацаатай байна.
- 2.8. Энэхүү журмын 2.7-д заасан хугацааг тогтоохдоо тусгай зөвшөөрөл болон түүнтэй адилтгах бусад зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэгч этгээдэд уг зөвшөөрлийн хугацаагаар, гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг бол уг гэрээний хүчинтэй хугацааг тус тус үндэслэн, тэдгээрт дүйцүүлэн Биржийн итгэмжлэлийн хугацааг тогтооно.
- 2.9. Бирж нь тухайн этгээдийг итгэмжлэх эсэх тухай шийдвэрийг шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор хүсэлт гаргагчид цахимаар, эсхүл бичгээр мэдэгдэнэ.
- 2.10. Бирж дараах тохиолдолд итгэмжлэхээс татгалзана. Үүнд:
- 2.10.1. Итгэмжлэл хүссэн өргөдөл, баримт бичгийг энэ журмын дагуу гаргаагүй;
- 2.10.2. Итгэмжлэл хүсэгч, эсхүл түүний гаргасан хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ журмаар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангагүй;
- 2.10.3. Өргөдлийн маягт болон энэхүү журмын 2.4-т тусгасан мэдээлэл хоорондоо зөрүүтэй;
- 2.10.4. Итгэмжлэл хүсэгч нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хориглох арга хэмжээг зөрчсөн нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон;
- 2.10.5. Энэхүү журмын 2.5-д заасны дагуу шаардсан нэмэлт мэдээлэл, баримт бичгийг тогтоосон хугацаанд бүрэн гаргаж өгөөгүй эсхүл гаргаж өгөх боломжгүй талаар үндэслэл бүхий тайлбар ирүүлээгүй;
- 2.11. Хүсэлт гаргагч нь итгэмжлэхээс татгалзсан тухай Биржийн шийдвэрийг эс зөвшөөрвэл зохицуулах эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй.
- 2.12. Бирж нь итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэл хөтлөх бөгөөд тэдгээрийн жагсаалтыг цахим хуудаст байршуулна.
- 2.13. Төрийн холбогдох эрх бүхий байгууллагыг итгэмжлэгдсэн этгээдээр бүртгэх тохиолдолд энэхүү журмын 2.4-т заасан зарим баримт бичгийг шаардахгүй.
- 2.14. Итгэмжлэгдсэн этгээдээр бүртгэгдсэн нь Бирж түүний өмнөөс хариуцлага хүлээх, тухайн этгээд Биржийг төлөөлж аливаа гэрээ хэлцэл байгуулах үндэслэл болохгүй.

Гурав. Итгэмжлэл олгоход тавигдах нөхцөл, шаардлага

- 3.1. Агуулах, терминалын итгэмжлэл хүсэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.1.1. Монгол Улсад бүртгэлтэй байх;

- 3.1.2. Монгол Улсын гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх, гаалийн хяналтын бүс тогтоох талаар олгосон зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байх;
- 3.2. Тээвэр логистикийн итгэмжлэл хүсэгч нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
 - 3.2.1. Улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн хувьд тухайн төрлийн бүтээгдэхүүнийг хилээр тээвэрлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй байх;
 - 3.2.2. Уул уурхайн бүтээгдэхүүн худалдагч этгээдээс тодорхойлж ирүүлсэн тээвэрлэгч этгээдийн жагсаалтад бүртгэлтэй байх;
- 3.3. Уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэлт хийх тохиолдолд хүсэлтийн дагуу энэхүү журмын 3.2-т заасан нөхцөл, шаардлагаас бүрэн болон хэсэгчлэн хөнгөвчилж болно.
- 3.4. Тээвэр логистикийн итгэмжлэл хүсэгчийн материалын бүрдлийн үнэн зөвийг түүнийг тодорхойлж ирүүлсэн худалдагч эсхүл итгэмжлэл хүсэгч хариуцна.
- 3.5. Худалдагчийн хүсэлтээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан ерөнхий гэрээ байгуулсан этгээдийг итгэжлэхэд энэ журмын 2.4 дэх хэсэгт заасан материалыг шаардахгүй байж болно.
- 3.6. Шинжилгээний лабораторийн итгэмжлэл хүсэгч нь дараах нөхцөл, шаардлага хангасан байна. Үүнд:
 - 3.6.1. Монгол Улсын үндэсний итгэмжлэлийн төвөөс олгосон холбогдох сорилт, шинжилгээ гүйцэтгэх итгэмжлэл хүчинтэй байх;
 - 3.6.2. Шинжилгээний лаборатори нь олон улсын болон дотоодын ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018) стандартын шаардлагыг хангасан байх;
- 3.7. Энэхүү журмын 3.1, 3.2, 3.6-д заасан этгээд нь Биржээс итгэмжилсэн хугацаанд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:
 - 3.7.1. Энэхүү журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах бөгөөд энэ талаар тайланг, нотлох баримтын хамт жил бүрийн 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Биржид ирүүлэх;
 - 3.7.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль тогтоомж, түүнтэй уялдан гарсан журам, зааварт заасан үүргээ бүрэн биелүүлж ажиллах;
 - 3.7.3. Холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн Зохицуулах Хороо (Цаашид “Хороо” гэх), Биржийн журамд нийтэд мэдээлэхээр заасан мэдээ, мэдээллийг биржийн цахим хуудсаар олон нийтэд хүргэх;
 - 3.7.4. Биржийн итгэмжлэл хүчинтэй байх хугацаанд Худалдагч талтай байгуулсан бүтээгдэхүүн хадгалах, тээвэрлэх, шинжилгээ хийлгэхтэй холбоотой гэрээг шинээр байгуулах, сунгах тохиолдолд холбогдох баримтыг ажлын 3 хүртэлх өдрийн дотор Биржид ирүүлэх;
 - 3.7.5. Хууль тогтоомжид заасан бусад шаардлага;

Дөрөв.Бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарыг баталгаажуулах, хадгалах, тээвэрлэх, чанарын хяналтыг зохион байгуулах

- 4.1. Биржээр арилжаалагдах уул уурхайн бүтээгдэхүүнийг агуулахад байршуулах тохиолдолд зөвхөн биржийн итгэмжлэгдсэн агуулахад байршуулна.

- 4.2. Хорооны 2023 оны 187 дугаар тогтоолоор батлагдсан “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”-ын 2.1.2 дах заалтын дагуу спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүн нь биржийн итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршиж, бүртгэгдсэн байна.
- 4.3. Бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдээр тээвэрлүүлнэ.
- 4.4. Худалдан авагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Худалдагч нь бүтээгдэхүүнийг арилжааны гэрээнд заасан газар хүргэх хугацааны тээвэрлэлтийн эрсдэлийг хариуцна.
- 4.5. Худалдагч болон Тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтийн хугацаанд гарах эрсдэлийг хоорондын гэрээгээр зохицуулна.
- 4.6. Худалдагч нь арилжаалах бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарыг Биржийн итгэмжилсэн шинжилгээний лабораторид шинжлүүлж баталгаажуулна.
- 4.7. Бүтээгдэхүүний чанарын хяналтыг Худалдагч тал хариуцна.
- 4.8. Итгэмжлэгдсэн үйл ажиллагаа эрхлэгч нь Бирж, брокер, бусад оролцогч этгээдтэй харилцан уялдаа холбоотой ажиллана.

Тав. Итгэмжлэгдсэн этгээдийн үндсэн чиг үүрэг

A.Итгэмжлэгдсэн агуулах, терминалын үндсэн чиг үүрэг

- 5.1. Итгэмжлэгдсэн агуулах, терминалын үйл ажиллагаа эрхлэгч нь уул уурхайн бүтээгдэхүүнийг Биржээр арилжих ажиллагаанд оролцоходоо дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
 - 5.1.1. Худалдагч талаас тээвэрлэгдэн ирсэн бүтээгдэхүүнийг бүртгэж, хүлээн авч, Худалдан авагч руу ачуулна.
 - 5.1.2. Бүтээгдэхүүнийг хүлээн авах, ачуулах үед агуулахын баримт үйлдэнэ. Агуулахын баримтад бүтээгдэхүүний нэр, код, худалдагч, тээвэрлэгчийн мэдээлэл, худалдан авагч тодорхой бол худалдан авагчийн мэдээлэл, жин, хүлээн авч, буулгасан огноо, бүтээгдэхүүн, итгэмжлэгдсэн агуулахын дугаар, хариуцсан ажилтны талаарх болон бусад шаардлагатай мэдээлэл тодорхой тусгагдсан байна.
 - 5.1.3. Бүтээгдэхүүний чанар, стандарт шаардлагын талаарх итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг хүлээн авч, Бирж болон зохих этгээдэд мэдээлнэ.
 - 5.1.4. Агуулахын бүртгэлийн мэдээллийг тогтмол үнэн зөв хөтөлж, Бирж болон зохих этгээдэд хүргүүлнэ.
 - 5.1.5. Бүтээгдэхүүний шинж чанарыг алдагдуулахгүй нөхцөлийг бүрдүүлж, Монгол Улсын холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.
 - 5.1.6. Хууль тогтоомж, зохицуулагч этгээдээс тогтоосон журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.2. Бирж болон Биржийн гишүүн брокер нь итгэмжлэгдсэн этгээдийн эрхлэх үйл ажиллагааны чиг, үүрэг, хариуцлагын талаарх нарийвчилсан харилцааг гэрээний үндсэн дээр зохицуулж болно.
- 5.3. Итгэмжлэгдсэн агуулахын үйл ажиллагаа эрхлэгч нь Биржийн гишүүн брокер, холбогдох хяналтын байгууллага, Биржээс итгэмжлэгдсэн тээвэр логистик, шинжилгээний лаборатори болон бусад оролцогч этгээдтэй харилцан уялдаа холбоотой хамтран ажиллана.

Б. Итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үндсэн чиг, үүрэг

- 5.4. Итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч нь уул уурхайн бүтээгдэхүүнийг Биржээр арилжих ажиллагаанд дараах чиг үүрэгтэй байна.
Үүнд:
 - 5.4.1. Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулахад болон агуулахаас худалдан авагчид хүргэхтэй холбоотой тээвэрлэлтийн асуудлыг хариуцна.
 - 5.4.2. Тээвэрлэлтийг худалдагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.
 - 5.4.3. Агуулах, терминалын илгээсэн бүтээгдэхүүнийг аюулгүй, баталгаатай хүргэж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ хугацаанд тээвэрлэлтийн горимыг баримталж, тээвэрлэж буй бүтээгдэхүүний чанар, хэмжээ, бүрэн бүтэн байдлыг Худалдагчийн өмнө хариуцна.
 - 5.4.4. Хууль тогтоомж, зохицуулагч этгээдээс тогтоосон журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.5. Бүтээгдэхүүнийг хүргэж өгөх хугацааг Биржээр арилжигдах бүтээгдэхүүний гэрээнд тодорхой тусгасан байна.
- 5.6. Худалдагч нь тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд тээвэрлэлтийн улмаас үүсэх хариуцлагыг Худалдагч өөрөө бүрэн хариуцна.
- 5.7. Төмөр замын ачаа тээвэрлэх итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн чиг үүрэг, стандартыг тус салбарын холбогдох хууль, журмаар зохицуулна.

В. Итгэмжлэгдсэн шинжилгээний лабораторийн үндсэн чиг, үүрэг

- 5.8. Итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаа эрхлэгч нь уул уурхайн бүтээгдэхүүнийг Биржээр арилжих ажиллагаанд дараах чиг үүрэгтэй оролцно.
Үүнд:
 - 5.8.1. Биржээр арилжаалах бүтээгдэхүүний чанар, стандартын баталгаажуулалтыг хариуцан гүйцэтгэнэ.
 - 5.8.2. Бүтээгдэхүүнийг агуулахад оруулсны дараа худалдагч болон лабораторийн харилцан тохирч, сонгосон этгээдээр дээж авахуулж, биржийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулна.
 - 5.8.3. Шинжилгээний үр дүнг бие даасан, хараат бус байдлаар гаргаж, зохих этгээдэд олгоно.
- 5.9. Лабораторийн шинжилгээний үр дүн нь лабораторийн нэр, лого, дээжийн мэдээлэл, шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, тухайн бүтээгдэхүүн, түүхий эдийн зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, гарсан үр дүн зэрэг мэдээллийг багтаасан байна.
- 5.10. Итгэмжлэгдсэн лаборатори нь өөрийн дүгнэлтийн үнэн зөвийг хариуцна.
- 5.11. Худалдан авагч нь итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөгжүү тохиолдолд худалдагч болон худалдан авагч талаас сонгосон биржийн итгэмжлэгдсэн гуравдагч лабораториор дахин шинжилгээ хийлгэн, баталгаажуулж болно.
- 5.12. Итгэмжлэгдсэн лаборатори нь шинжилгээнд дээж авсан, шинжилгээ хийсэн, шинжилгээний хариу өгсөн, дээж хадгалсан болон устгасан тухай бүртгэлийг хөтлөх бөгөөд, Бирж хүсэлт гаргасан тохиолдолд шинжилгээнд хамруулсан бүтээгдэхүүн, түүхий эдийн нэгдсэн мэдээ, тайланг хүргүүлнэ.

Зургаа. Хяналт, шалгалт, зөрчил хариуцлага

- 6.1. Бирж нь итгэмжлэгчээр бүртгэгдсэн этгээдийн энэхүү журмаар хүлээсэн үргийн биелэлтэд хяналт тавьж, шалгалт хийж болно. Шалгалтыг дангаар эсхүл бусад этгээдтэй хамтран хийж болох бөгөөд асуудлыг Хороо, хариуцлага ногдуулах эрх бүхий бусад байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 6.2. Итгэмжлэгдсэн этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн, эсхүл хэрэгжүүлээгүй тохиолдолд итгэмжлэгдсэн этгээдэд дараах хариуцлагын арга хэмжээнээс аль тохирохыг сонгон авна. Үүнд:
 - 6.2.1. Сануулах;
 - 6.2.2. Итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэлээс хасах
- 6.3. Итгэмжлэгдсэн этгээд ногдуулах хариуцлагын хэлбэрийг сонгохдоо Бирж нь итгэмжлэгдсэн этгээдийн гаргасан зөрчлийн шинж чанарыг харгалзан үзнэ.

Долоо. Итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэлээс хасах, хугацааг сунгах

- 7.1. Итгэмжлэгдсэн этгээд нь итгэмжлэлийн хугацааг сунгуулахдаа итгэмжлэлийн хугацаа дуусахаас ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Биржид цахимаар хүсэлт гаргана.
- 7.2. Итгэмжлэл сунгуулах хүсэлт гаргахдаа энэхүү журмын гуравдугаар зүйлд заасан итгэмжлэл олгогдоход тавигдах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаж байгаа талаар нötлох баримт бичгийг хамт ирүүлнэ.
- 7.3. Энэхүү журмын гуравдугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж буй этгээдийн итгэмжлэлийн хугацааг энэхүү журмын 2.8 дахь хэсэгт заасныг харгалзан 3 хүртэл жилээр сунгана.
- 7.4. Итгэмжлэгдсэн этгээд нь итгэмжлэлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргаагүй нь итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэлээс хасах үндэслэл болно.
- 7.5. Итгэмжлэгдсэн этгээдийг дараах тохиолдолд итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэлээс хасна. Үүнд:
 - 7.5.1. Итгэмжлэгдсэн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрөө хүсэлт гаргасан;
 - 7.5.2. Итгэмжлэгдсэн үйл ажиллагаа эрхлэгч нь татан буугдсан, дампуурсан, итгэмжлэл олгогдсон үйл ажиллагааны чиглэлийг өөрчилсөн;
 - 7.5.3. Итгэмжлэлийн хугацаа дууссан, энэ журмын 7.1-д заасан хугацаанд итгэмжлэлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргаагүй;
 - 7.5.4. Итгэмжлэгдсэн этгээд нь агуулахын болон тээвэрлэлт, лабораторийн шинжилгээний баримт бичгийг хуурамчаар үйлдсэнийг эрх бүхий этгээд тогтоосон;
 - 7.5.5. Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэгчийн хувьд тухайн тусгай зөвшөөрөл хүчингүй болсон;
- 7.6. Итгэмжлэлийн хугацааг сунгах, бүртгэлээс хасах асуудлыг баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Биржийн Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

7.7. Журмын 7.6-д заасан шийдвэрийг шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор итгэмжлэгдсэн этгээдэд цахимаар эсхүл бичгээр мэдэгдэнэ.

Найм. Бусад

- 8.1. Итгэмжлэл хүсэгч болон итгэмжлэгдсэн этгээд нь бүртгэлтэй холбоотой Биржийн аливаа шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд гомдол гаргаж болно.
- 8.2. Энэхүү журмын хавсралт нь журмын салшгүй хэсэг байна.

~оOо~

Нэгдүгээр хавсралт.

ИТГЭМЖЛЭЛ ХҮССЭН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Бид дараах байдлаар итгэмжлүүлэхийн тулд энэхүү өргөдлийг гаргаж байна:


Итгэмжлэл шинээр Итгэмжлэл сунгах Хасах

1 Компанийн өрөнхий мэдээлэл				
1.1 Компанийн нэр				
1.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар				
1.3 Регистрийн дугаар				
1.4 Компанийн харьяалал				
1.5 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ				
1.6 Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн мэдээлэл (итгэмжлэлийн төрлөөр)	Зөвшөөрөл олгосон этгээд, шийдвэрийн дугаар	Зөвшөөрөл авсан огноо	Дуусах хугацаа /он. сар. Өдөр/	
Агуулах				
Терминал				
Тээвэр логистик				
Шинжилгээний лаборатори				
2 Хаяг, байршил				
2.1 Ажлын байрны талаарх мэдээлэл	<input type="checkbox"/> Өөрийн	<input type="checkbox"/> Түрээс	<input type="checkbox"/> Холимог	
2.2 Байршил	<ul style="list-style-type: none"> Агуулахын/Терминалын/Тээврийн/Шинжилгээний лабораторийн нэр, албан ёсны болон байршил тодорхойлох хаяг 			
2.3 Веб сайт				
2.4 Цахим шуудангийн хаяг				
2.5 Ажлын утас, факс				
3 Үүсгэн байгуулагч болон 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид				
№	Овог, нэр	Оруулсан хөрөнгийн		Ажил эрхлэлтийн байдал
		Үнийн дүн	Хувь	

4	Төлөөлөн удирдах зөвлөл				
№	Овог, нэр	Албан тушаал		Ажил эрхлэлтийн байдал	
1					
2					
3					
4					
5					
6					
5	Санхүүгийн үзүүлэлт /..... оны сарын -ны байдлаар (жилийн дүнгээр)/				
№	Үзүүлэлт	Актив		Пассив	
1	Нийт хөрөнгө				
	Эргэлтийн хөрөнгө				
	Эргэлтийн бус хөрөнгө				
2	Өр төлбөр, Эзэмшигчийн өмчийн дүн				
	Өр төлбөр				
3	Эзэмшигчийн өмч				
	Нийт орлого				
4	Үндсэн үйл ажиллагааны орлого				
	Бусад орлого				
5	Нийт зардал				
	Цэвэр ашиг /алдагдал				
6	Аудит хийсэн компани	Hэр:	Хаяг:		
6*	Хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл /тээврийн хэрэгслийг хадгалах байр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт гэх мэт/.				
№	Хөрөнгийн жагсаалт	Тоо хэмжээ	Нийт үнийн дүн	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Өөрийн эзэмшил /эсхүл Түрээс
1					
2					
3					
7*	Удирдах албан тушаалтан болон Ажиллагсдын мэдээлэл /салбарыг оролцуулна/				
№	Ажилтнуудын овог, нэр	Албан тушаал	Ажил орсон огноо	Мэргэшсэн үнэмлэх эсхүл дипломын дугаар	
1					
2					
3					

*- Биржээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бөглөх мэдээлэл

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн итгэмжлэгдсэн этгээдээр бүртгүүлэхээр өргөдөл гаргагч “.....” компани нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-д ирүүлсэн материалын үнэн зөвийг хариуцах бөгөөд хуурамч, худал мэдээлэл ирүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ. Итгэмжлэгдсэн этгээдээр бүртгэгдсэнээр цаашид Монгол Улсын хууль тогтоомж, уул уурхайн бүтээгдэхүүний зохицуулалттай зах зээлд мөрдөгдөж буй Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн холбогдох журам, заавраар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллахыг БАТАЛЖ байна.



Тамга

Захирал

/ Гарын үсэг/

20... оны ... сарын ... -ний өдөр